




18th Story

Пилатын шүүлтэнд орсон нь!

Trial with Pilate and Herod

Пилатын шүүлтэнд орсон нь!

– 18th Story –



Өгүүлэгч Есүс тэргүүн тахилч Каиафыг явсаны дараа Ромоос томилсон Израилийн захирагч Пилат руу хүргэгдэв. Өглөө эрт тэргүүн тахилч, ахлагчид Есүс хүлж аваад явав. Тэд Пилатад хэлсэн.

Тэргүүн тахилч Энэ хүн хүмүүсийг буруу замаар турхирсан том нүгэл үйлдсэн. Тэр Цезарьт татвар өгөхийг эсэргүүцэж, өөрийгөө иудейчүүдийн хаан гэж баталж явсан.

Өгүүлэгч Пилат Есүсээс асууж эхэлсэн.

Пилат Үнэн үү? Хмм.. Та иудейчүүдийн хаан юмуу?

Есүс Та ч хэлж байна.

Пилат Хм.. за за ... Та тэр тэргүүн тахилчид, ахлагчид ямар олон зүйл таны эсрэг тулгаж байгааг мэдэж байна уу? Тэд таныг алахыг хүсч байна. Мэдэж байна уу?

Өгүүлэгч Есүс юу ч хэлсэнгүй. Хүмүүс Есүсийн талаар ярьж буй зүйлсэд ч хариулсангүй. Пилат тэргүүн тахилчид болон ахлагч нар руу буцаж очоод Есүсийг хөнөөх шалтгааныг олж чадсангүй гэж хэлэв. Тэгмэгц тэд Пилатыг бүр дарамталсан.

Тэргүүн тахилч Тэрний сургаал нь бүх иудейчүүдийг самууруулж орхисон.

Ахлагч Галилаас эхэлсэн боловч одоо энд Иерусалим хүртэл бүгд тархлаа.

Пилат Галил гэж хэлсэн үү? Тэр чинь Херодын захирдаг нутаг биш үү? Олигтойхон байцаахын тулд Есүсийг Херод руу явуулъя.

Тэргүүн тахилчид, ахлагчид болохгүй. Тэр үхэх нь зохистой. Бид түүнийг алахыг хүсэж байна.

Өгүүлэгч Пилат Есүсийг Галилыг захирдаг Херод руу явуулав. Есүс тэнд очиход Херод сэтгэл нь хөдөлсөн. Херод хаан Есүсийн үйлдсэн зүйлсийг сонссон бөгөөд гайхамшиг үйлдэхийг нь ч харахыг хүссэн. Херод Есүсээс олон асуулт асуусан боловч Есүс мөн л юу ч хариулсангүй. Тэргүүн тахилчид болон ахлагч нар тэнд Есүс рүү хашгирч Түүнд зарга мэдүүлэх зүйлсийг авчирчээ. Харин Херод болон түүний цэргүүд зүгээр инээж байлаа.

Херод Одоо надаар тоглоод байна уу. Таны тухай их сонссон. Харин одоо миний уулзсан Есүс Та ... үнэхээр харамсалтай юм. Та бол асар их гайхамшгийг үйлддэг хүн байх ёстой атал зүгээр л нэг жирийн хүн юм(шоолон). Бид өөрчилж чадна аа. Харж бай. Есүст өөрийнх нь нэрэнд тохирсон хувцас өг.

Өгүүлэгч Херод Есүсийг дооглож байлаа. Тэр цэргүүддээ тушаан Есүст маш гоё хувцас өмсгөж үргэлжлүүлэн шоолж инээлдэцгээв. Тэгээд Есүсийг дахин Пилат руу явуулжээ.

Херод Энэ хүнийг надаас хол явуул. Яагаад над руу явуулсныг огт ойлгохгүй нь.

Өгүүлэгч Есүс дахиад л Пилат руу хүргэгдлээ. Энэ удаа Есүсийг хүрч ирэхэд Пилат Есүсийг хувцастай байгааг нь хараад инээв. Тэгээд тэргүүн тахилчид, ахлагч нарт хэлсэн.

Пилат Хар даа. Та нар энэ хүнийг над руу дагуулж ирсэн. Тэгээд энэ хүн хүмүүсийг эрх баригчдаас нүүр буруулуулсан гэж хэлсэн. Би та нарын өмнө энэ хүнээс асуусан, та нарын зарга мэдүүлсэн зүйлээс ямар ч нотолгоо олоогүй. Херод ч гэсэн яг адилхан учраас дахид л над руу явуулсан байна. Та нарын харсанчлан энэ хүн цаазаар авхуулах ямар ч хэрэг хийгээгүй. Тиймээс би түүнийг ташуурдаад л суллана.

Өгүүлэгч Тэргүүн тахилчид болон ахлагчид энэ үгийг сонсмогцоо гал шиг уурласан бөгөөд дахиад л бүгд хашгирцгаав.

Тэргүүн тахилчид,
ахлагчид

Пилат болохгүй ээ, түүнийг ал. Тэр үхэх ёстой. Тэр худалч ойлголоо, ойлголоо. Чимээгүй байцгаа. Та нар ч гэсэн мэдэж байгаа, Алгасал баяраар захирагч нэг хоригдлыг сулладаг журамтай. Хэнийг суллуулахыг хүсэж байна уу? Алуурчин Бараб уу? Эсвэл Иудейчүүдийн хаан гэж өөрийгөө хэлдэг Есүсийг үү?

Тэргүүн тахилчид,
ахлагчид

Пилат Бараб! Бид Иудейчүүдийн хааныг хүсэхгүй! Барабыг сулла!


Пилат Чимээгүй. Үүнийг хар, нааш ир. Та нар үнэхээр та нарын хаан гэж буй Нэгнийг биш алуурчныг суллахыг хүсэж байгаа уу?

Тэргүүн тахилчид,
ахлагчид

Пилат Тиймээ, тэгэж байна. Зүгээр л хэлж байна. Тэгээд та нар Иудейчүүдийн хаан гэж байгаа тэр хүнийг намайг яа гэж байгаа юм бэ?

Тэргүүн тахилчид,
ахлагчид

Пилат Загалмайд цовдол.





Пилат Загалмайд цовдол гэнээ? Яагаад? Миний харахад тэр хүн тийм муу зүйл хийгээгүй. Үхэх шалтгаан ч байхгүй байхад загалмайд цовдолж ал гэж үү?

Өгүүлэгч Тэргүүн тахилчид, ахлагч нар ихэд уурлан сэтгэлээ өөрчлөх гэсэнгүй. Тиймээс Пилат тэдний өмнө тавагтай ус авчираад гараа угаав.

Пилат Би энэ хүний үхэлд ямар ч нүгэл байхгүй. Та бүгдэд хариуцлага бий.

Тэргүүн тахилчид,
ахлагч нар

Мэдлээ. Бид болон бидний бүх үр хүүхдүүд бүх шийтгэлийг авна.

Өгүүлэгч Захирагч Пилат Барабыг суллаад, гэм нүгэлгүй Есүсийг ташуурдсаны дараа загалмайд цовдлуулахаар явууллаа.